



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 07 сарын 30 өдөр

Дугаар А/268

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5-ын "а", Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, 18.2.1, заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх" дэд хөтөлбөр болон "Чингис хаан брэнд" дэд хөтөлбөрийн хүрээнд Чингис хотод 2018 оны 08 дугаар сарын 17-18-ны өдрүүдэд зохион байгуулагдах "Чингис фестиваль – 2018" олон улсын ардын урлагийн хоёрдугаар наадмын ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

| | | |
|-----------------------|---------------|---|
| Дарга: | Э.Мөнх-Эрдэнэ | -Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга |
| Нарийн бичгийн дарга: | Д.Цогт-Эрдэнэ | -Ардын дуу бүжгийн Хан Хэнтий чуулгын даргын үүргийг хавсран гүйцэтгэгч |
| Гишүүд: | Л.Бат-Октябрь | -Хууль, эрх зүйн хэлтсийн дарга |
| | Г.Лхагвахатан | -Нийгмийн бодлогын хэлтсийн дарга |
| | Б.Дархантөр | -Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга |
| | С.Мөнхцэцэг | -Боловсрол, соёл урлагийн газрын дарга |
| | Б.Энх-Эрдэнэ | -Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга |
| | Ч.Хос-Эрдэнэ | -Иргэний нийгмийн байгууллагын сүлжээ тэргүүн |
| | С.Оюун-Эрдэнэ | -Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн |

2. "Чингис фестиваль – 2018" наадмыг өндөр түвшинд зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн дарга /Э.Мөнх-Эрдэнэ/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА